



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар A/74

Жаргалтхаан

**Э.Мөнхбатыг шагнахад  
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад Онцгой байдлын алба байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан гамшгийн аюулаас ард иргэдийн амь насыг авран хамгаалах, урьдчилан сэргийлэх үүргээ нэр төртэй биелүүлж үр бүтээлтэй ажиллаж буй Жаргалтхаан сумын Эрэн хайх, аврах бүлгийн аврагч, жолооч-холбоочин дэд ахлагч Э.Мөнхбатыг Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 100,000 (нэг зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 100,000 (нэг зуун мянган) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч З.Жанчивт нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (С.Ганбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232421171